



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 7/4

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Баянгол дүүргийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 46,900,000.00 (дөчин зургаан сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Ш.Эрдэнэбилэг, Баянгол дүүргийн Прокурорын газрын тамгын хэлтсийн дарга О.Ганбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007593

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
211 дугаар тогтоолын хавсралт

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Автомашины нэр, зориулалт, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2021 оны 44 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Ниссан кашкей, улсын дугаар 30-19 УНЛ, арлын дугаар SJNFBNJ10Z2377161	2011/2011	46,900,000.00	1,500,000.00	750,000.00
Нийт дүн			46,900,000.00	1,500,000.00	750,000.00
			(дөчин зургаан сая есөн зуун мянга)	(нэг сая таван зуун мянга)	(долоон зуун тавин мянга)